



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/379

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Цусны донорын дэлхийн өдөр"-ийг тохиолдуулан олон жил сайн дураараа цусаа бэлэглэн олон хүний алтан амь насыг аварч амьдрал бэлэглэх, цусны нөөц бүрдүүлэх ариун үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буй Ц.Лхагвасүрэн, М.Түвшинжаргал нарыг "Донор гэр бүл"-ээр өргөмжилж аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 30000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 30000 төгрөг/гучин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



02 01878
D/Zax-A/379-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 19-ний өдрийн
А/379 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр		Арга хэмжээ	Олгох шагнал
1	Ц.Лхагвасүрэн		Цусны донорын дэлхийн өдөр	30000
2	Ж.Наранбаатар			
Дүн				30000

-оОо-